

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ  
9 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
үйл ажиллагааны мэдээлэл**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн өргөтгөсөн хуралдаан 2019 оны 9-р сарын 18-ны өдөр хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:

- Аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын чанарыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулж буй ажил, цаашид авах арга хэмжээний тухай

- 2018, 2019 оны улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар аймагт хийгдсэн, хэрэгжиж байгаа ажлуудын явц, үр дүнгийн тухай

-Шагналын асуудал

-2019 онд хувьчлах үл хөдлөх хөрөнгийг худалдах үнийг тогтоох тухай

-Автомашин үнийг шинэчлэн тогтоох тухай

-“Архангайд үйлдвэрлэв” худалдааны төвийн барилгыг “Архангайд үйлдвэрлэв” ОНӨҮГ-т шилжүүлэх тухай

-Аймгийн ИТХ-ын ээлжит бус хуралдаан зарлах, эсэх тухай

**Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл**

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал 2019 оны 9-р сарын 13-ны өдөр хуралдаж аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын чанарыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулагдаж буй ажил, Соёлын биет бус өвийг хамгаалах аймгийн дэд хөтөлбөр, Сонгодог урлаг-3 аймгийн дэд хөтөлбөр, 2018, 2019 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар аймагт хийгдсэн, хийгдэж байгаа ажлуудын явц, үр дүн гэсэн дөрвөн асуудлыг хэлэлцсэн байна.

2019 онд улсын төсвийн хөрөнгөөр нийт 144.915.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 54 төсөл арга хэмжээ хэрэгжинэ. Үүнээс 2019 онд 42.262.3 сая төгрөгөөр санхүүжинэ. Аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалалтаар 5 төсөл арга хэмжээнд 275.6 сая төгрөг батлагдсанаас 4 төсөл арга хэмжээ нь шинээр хэрэгжих 1 төсөл арга хэмжээ нь урд оны дутуу санхүүжилт байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 7.302.6 сая төсөвт өртөг бүхий 26 төсөл арга хэмжээ хэрэгжинэ. Үүнээс 2019 онд 3.011.6 сая төгрөгөөр санхүүжинэ. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3 төсөл арга хэмжээнд 132.7 сая төгрөг үүнээс барилга байгууламж 120.0 сая төгрөг, тоног төхөөрөмж 12.7 сая төгрөг тус тус тусгагдаад байна.

Аймгийн удирдах ажилтны ээлжит шуурхай зөвлөгөөнийг 9-р сарын 25-ны өдөр 10.00 цагт аймгийн ЗДТГ-ын VIP танхимд зохион байгууллаа. Зөвлөгөөнд 51 удирдах ажилтан оролцохоос аймгийн ЗДТГ-ын нэгжийн дарга 4, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын агентлагийн дарга 14, төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын дарга 9, нийт 27 удирдах ажилтан оролцож, ирц 52.9 хувьтай байв.

Энэ удаагийн шуурхай зөвлөгөөнөөр аймгийн Засаг даргаас цаг үеийн шинжтэй 6 үүрэг даалгавар болон өмнөх шуурхай зөвлөгөөнүүдийн үүрэг

даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах, биелэлтийн явц, үр дүнгийн талаар тайлан мэдээг хугацаанд нь ирүүлж байх, анхаарч ажиллах талаар сум, байгууллагуудад үүрэг, чиглэл өглөө. Мөн үүрэг даалгаврын биелэлт ирүүлэхгүй байгаа, зөвлөгөөнд оролцохгүй байгаа удирдах ажилтнуудад зөвлөгөөний тэмдэглэлээр сануулга өгсөн байна.

“Архангай аймгийн тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2026” бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцыг танилцуулах, хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, түүний гарц шийдлүүдийг гаргах зорилгоор 9-р сарын 20-ны өдөр “Тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-Архангай аймагт” хэлэлцүүлгийг зохион байгуулж сумдын шийдвэр гаргагчид, иргэний нийгмийн багйууллагууд, хангайн бүсийн аймгуудын төлөөлөл гээд 100 гаруй хүн оролцсон байна.

Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн шийдвэр, төрийн албаны шинэтгэл, холбогдох дүрэм, журмыг сурталчлан таниулах ажлын хүрээнд 9-р сарын 16-наас 18-ны өдрүүдэд Төрийн албаны зөвлөлийн ажлын хэсэг Архангай аймагт арга зүйн сургалт зохион байгуулж зөвлөгөө, мэдээллээр хангасан байна.

Өвөлжилтийн бэлтгэл хангах тухай Засгийн газрын 2019 оны 285 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2019 оны 02 дугаар албан даалгаврын хэрэгжилттэй танилцах, эрчимжүүлэх, аймгийн нийт сумдад төв суурингийн болон мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажил, улсын болон орон нутгийн төсвөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын явцтай танилцах, холбогдох үүрэг даалгавар өгөх зорилгоор гурван ажлын хэсэг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдон 9-р сарын 9-11-ний өдрүүдэд бүх сумдад ажиллалаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, аймгийн ЗДТГ, аймгийн Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар зэрэг байгууллагуудын хамтарсан ажлын хэсэг 9-р сарын 17-ны өдөр Цэнхэр сумын Орхон багт хийгдэж байгаа нөхөн сэргээлтийн ажлын явцтай танилцлаа.

Одоогийн байдлаар Цэнхэр сумын Орхон багийн нутагт 5 компанийн 190 гаруй ажилтан, 66 машин техник хэрэгсэлтэйгээр ажиллаж, техникийн нөхөн сэргээлтийг 85 га-д, биологийн нөхөн сэргээлтийг 25 га-д тус тус хийгээд байна.

“Архангай түншлэл-2019” үзэсгэлэн худалдаанд 15 сум, Улаанбаатар, Дархан, Өвөрхангай, Завхан, Сэлэнгэ аймгуудын нийт 135 аж ахуй нэгж, иргэд төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ, сүү сүүн бүтээгдэхүүн, гурил гурилан бүтээгдэхүүн, модон эдлэл, бэлэн хувцас, гар урлалын бүтээгдэхүүн, гэр ахуйн цахилгаан бараа, эсгий ноосон бүтээгдэхүүн зэрэг 10 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн худалдаалж 99.3 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

“2019 оны II ээлжийн цэрэг халах, татах ажлыг явуулах тухай” аймгийн Засаг даргын 2019 оны 9-р сарын 12-ны өдрийн 463 дугаар захирамжаар цэрэг татлагын товчоог аймгийн ЗДТГ-ын даргаар ахлуулан 12 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд эмнэлгийн урьдчилсан үзлэгийг 11 суманд 10-р сарын 2-12-ны өдрүүдэд зохион байгуулна.

## **Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд Татвар төлөлтийн талаар**

Тайлант сард хүлээгдэж буй гүйцэтгэлээр улсын төсвийн болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 100 хувьтай байна.

Тайлант хугацаанд 8-р сарын нэмэгдсэн өртгийн албан татварын 215 тайлан цахимаар хүлээн авч тайлангийн ирцийг 99.5 хувьтай хангуулж, шалгуур үзүүлэлт хангаагүй байцаагчид хуваарилагдсан 20 тайланг тайлан хүлээн авах журмын дагуу хүлээн авч баталгаажууллаа.

Тайлант хугацаанд 16 иргэн, аж ахуйн нэгжид тендерт оролцох виз хүссэн, зээл авах, бусад төрлүүдээр лавлагаа тодорхойлолт гаргаж, цахимаар ирүүлсэн тайлан засварлах, хуулийн хугацаа сунгуулах, тоон гарын үсэг авах зэрэг 169 хүсэлтийг тайс системээр хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн 2 аж ахуйн нэгж, байгууллага, 4 иргэнийг “Татвар төлөгчийг бүртгэх журам”-ын дагуу хуулийн хугацаанд бүртгэн цахим тайлангийн системд хэрэглэгч үүсгэн татварын хууль тогтоомж, цахим тайлангийн талаар зөвлөгөө өгч хариуцсан байцаагчид мэдээллийг хүргүүлэн ажиллалаа. Татварын хэлтсийн facebook хуудасанд НӨАТ-ын тайлан ирүүлэх, ибаримтын тохиролын талаар 7 мэдээлэл бэлтгэн тавьсан.

Тайлант хугацаанд нэг цэгийн өрөөгөөр давхардсан тоогоор 40 гаруй иргэнд зөвлөгөө өгсөн байна.

Тухайн сард төлөвлөгөөт 6, төлөвлөгөөт бус 8 татвар төлөгч, өмнөх сарын 1 татвар төлөгч нийт 15 татвар төлөгчийг шалгахаас 10 татвар төлөгчийг шалгаж дууссан 4 татвар төлөгч шалгагдаж байна. Зөрчил илэрсэн 4 таван татвар төлөгчид Зөрчлийн хуулийн дагуу 16978.1 мянган төгрөгийн зөрчилд 2486.3 мянган төгрөгийн төлбөр ногдуулсан шийтгэлийн хуудсыг татвар төлөгчид зөвшөөрч гарын үсэг зурсан байна. Тайлант сард маргаантай акт буюу шийтгэлийн хуудас байхгүй, 5 татвар төлөгчтэй холбоотой 10 хөндлөнгийн мэдээлэл цуглуулж мэдээллийн санд бүртгэлээ.

#### **Өмч, худалдан авах ажиллагааны чиглэлээр**

Орон нутгийн өмчит 77 төсөвт байгууллагад 273.9 сая төг-ийн үндсэн хөрөнгө худалдан авах, 8 төсөвт байгууллагад 450 нэрийн 80.17 сая төг-ийн өртөг бүхий үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрлийг тус тус олгосон байна.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 3.200.9 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээний тендерийг нээсэн үнэлгээний шатанд байна

#### **Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд**

##### **Улсын бүртгэлийн чиглэлээр**

2019 ий 9-р сарын 25-ны өдөр иргэний бүртгэлийн чиглэлээр 1577 бүртгэл өгөгдөл ажлаа дуусгав.

- Шинээр төрсөн хүүхдээ бүртгүүлсэн төрөлт – 242
- Гэрлэлтийн бүртгэл - 41
- Гэрлэлт цуцалсаны бүртгэл - 3
- Хүүхэд үрчлэлтийн бүртгэл – 4
- Эцэг тогтоосны бүртгэл- 11
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсөний бүртгэл - 10
- Нас баралтын бүртгэл - 60
- Шинээр иргэний үнэмлэх олгосон - 139
- Дахин олгосон - 88
- Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 189
- Үндэсний энгийн гадаад паспорт- 77
- Шилжилт хөдөлгөөн - 178

- Иргэнд - 522 лавлагаа  
Хууль хяналтын байгууллагад - 13 лавлагаа

2019 оны 9-р сарын 25-ны байдлаар эд хөрөнгийн эрхийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэл 532 мэдүүлгийг хүлээн авч дараах бүртгэлийг хийж гүйцэтгэлээ.

- Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл – 22
- Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл - 15
- Шинээр бүртгүүлсэн орон сууцны бүртгэл – 3
- Газар эзэмших эрхийн анхны бүртгэл – 0
- Арилжааны гэрээ – 1
- Худалдах худалдан авах гэрээ – 62
- Бэлэглэлийн гэрээ – 9
- Барьцааны эрхийн бүртгэл – 356
- Өв залгамжлал – 8
- Хамтран өмчлөгч өөрчлөгдөх – 2
- Лавлагаа – 5
- Бусад эрхийн бүртгэл – 12

Хууль хяналтын байгууллагад нийт 21 лавлагааг гарган хүргүүлсэн байна. Дээрх бүртгэлүүдийг хийж улсын төсөвт үйлчилгээний хөлс 4810809 тэмдэгтийн хураамжид 78655 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдсанаас оруулсан татварын орлого 17191000 төгрөг төвлөрүүлсэн байна.

#### **Хуулийн этгээдийн чиглэлээр**

- Шинэ-5
- Өөрчлөлт-5
- Тамга тэмдэгтийн хяналтын дугаар олгосон-6
- 

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас Цэнхэр, Өгийнуур, Хотонт, Тариат, Ихтамир сумын нутагт аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй 13 жуулчны бааз, 1 амралтын газарт эрүүл ахуй халдвар хамгаалал, байгаль орчин, газар, геодези, зураг зүй, хүнсний чанар, стандартын хяналтын чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалт болон зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ундны болон бохир ус цэвэрлэх байгууламжийн уснаас 49 дээж авч хими, нян судлалын шинжилгээнд хамрууллаа.

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгч, улсын байцаагчдын хамтарсан 116 заалт бүхий 7 зөвлөмж, 75 заалт бүхий 6 албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч 3 жуулчны баазад Зөрчлийн тухай хуулиар 1.600.000 төгрөгийн торгууль, Цэцэрлэг сумын Мухар хужиртын рашаанд зөвшөөрөлгүй эмнэлгийн тусламж үзүүлж байсан 3 иргэнд 500.000 төгрөгийн торгууль, уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч 3 аж ахуй нэгжид 12 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээг авлаа.

Хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан Эрдэнэбулган сумын 6 сургууль, 14 цэцэрлэгт урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж багш, ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулан, хоол үйлдвэрлэлийн газарт хортон шавьжны ариутгал халдваргүйтлийг хийлгүүлж унд ахуйн хэрэглээний цэвэр ус

болон үдийн цай, хоолонд өгөх бүтээгдэхүүний 5 газрын 27 дээжийг шинжилгээнд тус тус хамрууллаа.

Шүүхийн шинжилгээний албанаас 9-р сард криминалистикийн шинжилгээ 1, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт 47, шүүх эмнэлгийн шинжилгээ 47, тусгай шинжилгээ 24-г тус тус хийсэн байна.

Аймгийн хэмжээнд 9-р сард тус аймагт нийт гамшиг осол, аюулт үзэгдлийн 8 удаагийн дуудлага ирсний дотор объектын гал түймрийн 5, гол, нуурын усанд унаж осолдсон 2, эрэн хайх аврах ажиллагааны дуудлага 1 удаа тус тус ирсэн байна.

## **Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд**

### **Боловсролын чиглэлээр**

2019-2020 оны хичээлийн жилд төрийн өмчийн 30, хувийн хэвшлийн 3, нийт 33 ерөнхий боловсролын сургуульд 18186 сурагч суралцаж, 1841 багш, ажилчид ажиллаж байна.

Сургуулийн өмнөх боловсролын төрийн өмчийн 34, хувийн хэвшлийн 1, нийт 35 цэцэрлэгт 7691 хүүхэд суралцаж, 698 багш, ажилчид ажиллаж байна.

Монголын соёл урлагийн ажилтны өдрийн баярын арга хэмжээг 9-р сарын 13,14-ний өдрүүдэд батлагдсан удирдамж, хөтөлбөрийн дагуу зохион байгуулж Нийтийн номын сан, Музей, Хөгжимт драмын театр болон 19 сумын Соёлын төвийн төлөөлөл болсон 120 орчим соёл урлагийн ажилтнууд оролцлоо.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын чанарыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулж буй ажил, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл бэлтгэн аймгийн Засаг даргын зөвлөлийн 9-р сарын 13-нд танилцуулж, 9-р сарын 18-ны өдөр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлсэн байна.

### **Соёл урлагийн чиглэлээр**

Аймгийн Нийтийн номын сан нийтийн уншлагын танхимаар 40 уншигч шинээр бүртгэж, 200 ирэгсэдэд 250 ном, 70 сонин, сэтгүүлээр, хүүхдийн уншлагын танхимаар 24 уншигч шинээр бүртгэж, 1225 ирэгсэдэд 2264 номоор, гэрээр ном олгох үйлчилгээгээр 108 ирэгсэдэд 176 ном, 25 сонин, зөөврийн номын сангийн үйлчилгээгээр 10 уншигч шинээр бүртгэж, 50 ирэгсэдэд, 100 номоор тус тус үйлчилсэн байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газраас зарласан “Уламжлал-Ирээдүй” аяны хүрээнд “Өв соёл” танин мэдэхүйн тэмцээнийг Соёлын өвийг тээгч Х. Батбаяртай хамтран Эрдэнэбулган сумын ЕБС-иудын ахлах бүлгийн сурагчдын дунд аймгийн Хөгжимт драмын театрт зохион байгууллаа.

Тэмцээнд сургууль тус бүрээс 6 хүний бүрэлдэхүүнтэй 5 баг оролцож, “Монголын нууц товчоо”, “Монгол ардын аман зохиол”, “Эх хэл-Монгол бичиг”, “Үндэсний наадгай”, “Таван хошуу мал” гэсэн 5 өртөөгөөр мэдлэг чадвар, ур чадвараа сорьсноос Лаборатори 1-р сургуулийн Ц.Цэрэнбалжид багшийн бэлтгэсэн “Дөрвөн бэрх”, “Өв соёл” багууд тэмцээний тэргүүн, дэд байрыг тус бүр эзэлж, өргөмжлөл, медалиар шагнагдсан байна.

Засгийн газрын 2019 оны 69 дүгээр тогтоолоор баталсан 2019-2024 онд хэрэгжих "Чулуун соёлын өв" үндэсний хөтөлбөрийн хүрээнд Соёлын өвийн үндэсний төвөөс аймгийн Музей, аймгийн ЗДТГ, ГХБХБГ, сумын ЗДТГ-тай хамтран Ихтамир сумын Тайхар чулуу, Өндөр-Улаан сумын Их Жаргалантын буган чулуун

хөшөөний цогцолборын хамгаалалтын бүсийг тогтоож, кадастр улсын бүртгэлд бүртгүүлэх судалгааны ажлыг 9-р сарын 17-ны өдөр зохион байгууллаа.

### **Эрүүл мэндийн чиглэлээр**

“Геронтологи, гериатрийн үндсэн ойлголт, орчин үеийн оношилгоо, эмчилгээний чиг хандлага” сургалт 2019 оны 9-р сарын 9,10-ны өдрүүдэд аймгийн Эрүүл мэндийн газарт боллоо. Сургалтад аймгийн Нэгдсэн эмнэлгийн ахмадын кабинетийн эмч, сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч зэрэг 60 гаруй эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдлаа.

Дэлхийн эрүүл мэндийн тэргүүлэх чиглэл болох “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал” сэдвийн дор “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын төлөө дуу хоолойгоо нэгтгэцгээе” уриатайгаар тус тэмдэглэлт өдрийг орон нутгийн түвшинд 2019 оны 9-р сараас 10-р сарын 01-ний хооронд тэмдэглэн өнгөрүүлж байна. Тус тэмдэглэлт өдрийн хүрээнд үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлын талаар байгууллага, мэргэжилтнүүдийг шинэ мэдээллээр хангах, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын зорилтуудын хэрэгжилтийн талаар эрүүл мэндийн байгууллагуудын сайн туршлагыг сонсох, түгээн дэлгэрүүлэх, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх мэдээлэл сурталчилгааны материал, түгээх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах зэрэг ажлуудыг хэрэгжүүлж байна.

### **Биеийн тамир, спортын чиглэлээр**

Монголын хүүхдийн спортын VI их наадамд 21 аймаг, 9 дүүргээс шалгарсан үндсэн 19, сонгох 5, өвлийн спортын 2, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 11 нийт 37 спортын төрөлд 5600 гаруй тамирчид оролцож хурд хүчээ сорин өрсөлдлөө.

Монголын хүүхдийн спортын VI наадам нь Улаанбаатар хотод 2019 оны 9-р сарын 05-15-ны өдрүүдэд болсон бөгөөд Архангай аймгаас энэхүү наадамд спортын үндсэн 11 төрөлд, өвлийн спортын 1 төрөлд нийт 96 тамирчин 16 дасгалжуулагчтай оролцож алтан медаль–4, мөнгөн медаль–8, хүрэл медаль–12 нийт 24 медаль авч багийн дүнгээр улсын хэмжээнд 12 дугаар байрт шалгарлаа.

Жүдо бөхийг үндэслэгч Жигоро Кано багшийн нэрэмжит багийн олон улсын тэмцээн ОХУ-ын Владивосток хотод 9-р сарын 4-5-ны өдрүүдэд боллоо.Тус тэмцээнд 2019 оны өсвөрийн аварга болсон өсвөрийн жүдочид эх орноо төлөөлөн оролцжээ. Үүний дотор Архангай аймгийн Б.Батдэлгэр дасгалжуулагчтай Н.Мэндсайхан 50 кг-д, Л.Мягмарсүрэн 66 кг-ийн жинд оролцсон байна. Тэмцээнд манай улсаас оролцсон эрэгтэй баг 2-р байр, эмэгтэй баг 1-р байр, холимог баг 3-р байранд орж нийлбэр дүнгээр ОХУ-ын багтай оноо тэнцэж, 1-р байранд орсон амжилт гаргажээ.

### **Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр**

2019 оны 9-р сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхитэй хайгч 804 иргэн бүртгэлтэй байгаагаас 429 эмэгтэй, Байнгын шинэ ажлын байр 612, түр ажлын байр 147, ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 638, зуучлал 611 байна. 8 сарын 25-ны байдлаар 224 иргэн нь шинээр бүртгүүлж, LMIS программд шивж оруулсан. Ажил идэвхитэй

хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилвал: боловсролгүй- 6, бага-30, суурь-136, бүрэн дунд-475, техникийн болон мэргэжлийн анхан шатны – 18, тусгай мэргэжлийн дунд-14, Дипломын бакалаврын-123, магистр-2 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэн ажилласан байна. Шинэ ажлын байрыг эдийн засгийн салбараар нь ангилвал: Хөдөө аж ахуйн салбарт 233, боловсруулах үйлдвэрлэлд 246, Бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний салбарт 25, бусад салбарт 255 ажлын байр шинээр бий болсон байна. Ажлын байранд зуучлагдан орсон иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилвал: Хөдөө аж ахуйн салбарт 238, боловсруулах үйлдвэрлэлд 23, барилга 25, үйлчилгээний болон бусад салбаруудад 325 иргэн зуучлагдан орсон байна. Тухайн сард ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирсэн 11 иргэнийг LMIS програмд шивж оруулан тодорхойлолт гарган өгч НДХ-т хүргүүлсэн.

Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрийн хүрээнд дараах сургалтуудыг эхлүүлээд байна. “Хоршооны мэдээлэл” сургалтын байгууллагатай хамтран Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах мэргэжил олгох сургалтанд 23 иргэн, “Мөнх оюуны холбоос” сургалтын байгууллагатай хамтран Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах мэргэжил олгох сургалтыг Цэнхэр суманд зохион байгуулж 20 иргэн, “Дарь овооны эзэд” сургалтын байгууллагатай хамтран Цэцэрлэгийн туслах багшийн мэргэжил олгох сургалтанд 20 иргэн хамрагдаж байна.

9-р сарын 07-ны өдөр аймгийн Нэгдсэн эмнэлэг, НДХ, ХХҮГ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоодын зөвлөл, Тэргэнцэртэй иргэдийн холбооны дэргэдэх “Манлайлагч эмэгтэйчүүд” бүлэг хамтран Эрдэнэбулган сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдний асран хамгаалагч нарт эрүүл мэнд, нийгмийн даатгал, халамжийн үйлчилгээний чиглэлээр сургалт мэдээлэл хийлээ. Энэхүү үйлчилгээнд Эрдэнэбулган сумын 25 хөгжлийн бэрхшээлтэй болон асран хамгаалагч нар хамрагджээ.

### **Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр**

“Нийгмийг өөрчлөх боловсрол” залуучуудын хөгжлийн сарын аяны хүрээнд “Залуусын дуу хоолой” дууны уралдаан, “Мэргэжил бүхэн сайхан”, “Гүүе, түүе” челленж арга хэмжээ, “Нэг сард 1 сайн дурын ажил” арга хэмжээг залуучууд болон байгууллагуудыг идэвхитэй хамруулан зохион байгуулсан.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд 8 дуудлага мэдээлэл ирсэн ба эдгээрийг шийдвэрлэх чиглэлийг хамтарсан багт өгч, Эрдэнэбулган, Ихтамир, Цэнхэр, Өлзийт, Жаргалант сумдын хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр албан шаардлага хүргүүллээ.

2 гэр бүлд 4 удаагийн гэр бүлийн зөвлөгөө, түр хамгаалах байраар үйлчлүүлж буй 3 үйлчлүүлэгчдэд нийт 10 удаагийн сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн байна.

### **Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд**

#### **Мал аж ахуй**

“Өвөлжилтийн бэлтгэл хангах тухай” Засгийн газрын 2019 оны 285 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2019 оны 02 дугаар албан даалгаврын дагуу 2019 онд малчдын түвшинд 80.0 мянган тн байгалийн хадлан, 1320 тн гар тэжээл, аймаг сумдын аюулгүй нөөцөд 1900 тн өвс, 570 тн тэжээл бэлтгэн нөөцлөхөөр төлөвлөн

бэлтгэлийг ханган ажиллаж байна.

2019 оны 9-р сарын 24-ний байдлаар малчдын түвшинд 70.5 мянган тн өвс бэлтгэж 88.2 хувьтай, 927 тн гар тэжээл 70.2 хувь, аймаг сумдын аюулгүй нөөцөд 731.2 тн өвс, 137.7 тн гар тэжээл бэлтгэсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн “Намрын ногоон өдрүүд 2019” үзэсгэлэн худалдаа 9-р сарын 18-24-ний өдрүүдэд “Мишээл экспо” төвд болж Өндөр-Улаан, Хотонт, Эрдэнэбулган сумдаас сүү, цагаан идээгээр оролцож 8.6 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Засгийн газрын 2015 оны 122 дугаар тогтоолын дагуу 2019 онд хонь, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан 19 сумын 6117 малчны 1715.7 тн ноосны анхан шатны баримтыг бүрдүүлж Мал хамгаалах санд хүргүүлсэн.

Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоотой хамтран орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэх, малчид болон түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх, түүхий эд болон түүхий эд бэлтгэлийн чанарыг сайжруулах, үйлдвэрлэлийн үргүй зардлыг бууруулах, түүхий эд бэлтгэлийн тогтолцооны үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор 2019 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр Хотонт суманд “Ноосон түүхий эдийн чанар, түүхий эд бэлтгэлийн стандарт” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Сургалтад Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо, Нэмүү өртгийн сүлжээг дэмжих төсөл, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга мэргэжилтэн, 17 сумын Засаг дарга, Хөдөө аж ахуйн тасаг, Мал эмнэлгийн тасаг, малчид, холбооны итгэмжлэгдсэн төлөөлөгч болон түүхий эд бэлтгэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хоршоодын төлөөлөл нийт 150 хүн хамрууллаа.

### **Газар тариалан**

Архангай аймаг 2019 онд үр тариа 9040 га, тэжээлийн таримал 1097.9 га, төмс 264.3 га, хүнсний ногоо 126.5 га, тосны таримал 650 га, нийт 11 179.7 га талбайгаас ургац хураан авна.

2019 оны 9-р сарын 24-ний байдлаар Ургац хураалт 53 хувьтай явагдаж байна. Үүнд: 4315 га-гаас 5161 тн үр тариа, 850 га-гаас 2975 тн тэжээлийн ургамал, 195 га-гаас 2301 тн төмс, 98 га-гаас 1176 тн хүнсний ногоо, 450 га-гаас 360 тн тосны таримал нийт 5908 га талбайгаас 11973 тн ургац хураан авсан.

Ургац хураалтын ажилд комбайн 29, хадагч жатка 31, будаа цэвэрлэгч 5, үр сортлогч 1, будаа ачигч 7, төмс ухагч 24, түлш цэнэглэгч автомашин машин 3, тээврийн 20 гаруй авто машин, 30 гаруй тэвш ажиллаж байна.

Мөн инженер агрономич 17, 80 гаруй механикжуулагч тракторчин комбайнчин, 200 гаруй ногоочин, 100 гаруй оюутан сурагчид ургац хураалтад ажиллаж байна.

### **Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд**

#### **Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр**

Ойн салбарын 95 жилийн ой, ой модны салбарын ажилчдын баярын өдрийг тохиолдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Ойн хөгжлийн төвөөс аймаг нийслэлийн ойн нэгж, ойн ангийн мэргэжилтнүүдийг чадавхижуулах нэгдсэн зөвлөгөөнд мэргэжилтэн, сум дундын ойн ангийн инженерүүд хамрагдлаа.



Зөвлөгөөний үеэр ойн ангийн инженерүүдийн дунд зохион байгуулагдсан "Мод бэлтгэлийн талбай тусгаарлах, ойн таксацын үнэлгээ тогтоох", "Үр боргоцой түүх, таних", "Ойжуулалтын ажлын сорил" Хөрөөчний ур чадварын тэмцээнийг зохион байгуулсан байна. "Мод бэлтгэлийн талбай тусгаарлах, ойн таксацын үнэлгээ тогтоох", ур чадварын тэмцээнд Архангай аймгийн ойн анги тусгай байр эзэлсэн байна.

Байгаль орчныг хамгаалах тухай, Ойн тухай, Амьтны тухай, Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, хууль бус мод бэлтгэлт, ан агнуурын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хариуцлага тооцох зорилгоор аймгийн Цагдаагийн газар, Прокурорын газар, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газрын зөрчил шалган шийдвэрлэх албан тушаалтнууд хамтран 1 сарын нэгдсэн хяналт шалгалтын аян зохион байгуулж байна.

Хөдөлгөөнт хяналт шалгалтын хугацаанд илрүүлсэн ойн баялаг, ангийн эд зүйлийг хураан авч Зөрчил хянан шийдвэрлэх албан тушаалтанд шилжүүлсэн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Орхон Чулуут голын сав газрын захиргаа хамтран "Хоггүй, цэвэрхэн Монгол", "Ногоон паспорт" аяны хүрээнд Хүмүүн 3-р сургуулийн Эко клубын 270, Өгийнуур сумын 20 гаруй сурагчдын дунд явган аялал зохион байгуулж, Тарвуугийн гол болон Өгийнуур ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэн 15 тн хог хаягдлыг хогийн цэгт төвлөрүүлсэн байна.

Орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэхийн ач холбогдол, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хамтрагч талуудын хамтын ажиллагааг сайжруулах гарц, шийдэл, 2020 онд хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааныхаа чиглэлийг тодорхойлох зорилготойгоор "Архангай аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэхэд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоо, хамтын ажиллагаа" сэдвийн хүрээнд ажил хэргийн уулзалтыг 9-р сарын 27-ны өдөр Цэнхэр сумын нутаг дахь "Дуут ресорт" жуулчны баазад зохион байгууллаа.

### **Барилга, дэд бүтцийн чиглэлээр**

2019 онд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 08 дугаар тогтоолоор аймгийн төсөвт газрын төлбөрөөс нийт 60000.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 9-р сарын 27-ны өдрийн байдлаар 64915.0 мянган төгрөг төвлөрүүлж биелэлт 108.2 хувьтай бна.

Газрын дуудлага худалдаанаас 2019 онд 232073.2 мянган төгрөг төвлөрөхүүлэхээс 8-р сарын байдлаар 281526.7 мянган төгрөг төвлөрүүлж биелэлт 121.3 хувьтай байна.

2019 онд Архангай аймагт Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамны 19.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгөөр 16 төсөл арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнээс 3 төсөл арга хэмжээ байнгын ашиглалтанд хүлээн авсан, 4 төсөл арга хэмжээ он дамжин хэрэгжиж байгаа бөгөөд үлдсэн 9 төсөл арга хэмжээг 2019 онд багтаан ашиглалтанд оруулахаар ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн засварын ажлыг хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан ашиглалтанд оруулсан болно.

Мөн 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд аймгийн Засаг даргын удирдамжаар томилогдсон 3 ажлын хэсэг хөдөөгийн 18 суманд ажиллаж төрийн байгууллагын өвөлжилтийн бэлтгэл ажил, инженерийн шугам сүлжээний

бэлтгэл арга хэмжээ, уурын зуухны үйл ажиллагаа, нүүрс татан авалт зэрэгтэй газар дээр нь танилцан заавар зөвлөмж өгсөн байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР